



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 203

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77,3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журамын 3 дугаар зүйлийн 3.1“д” 3.2.6-гийн “а”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 808'500 /найман зуун найман мянга таван зуун/ төгрөгийн өртөгтэй аж ахуйн модон складын худалдах доод үнийг 500'000 /таван зуун мянган/ төгрөгөөр тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Худалдагдсан хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч /М.Туул/-д даалгасугай.

3. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ

